


# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-10 САР)

Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2015 оны 10 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 5,124 орон сууцны үнийг хамруулсан болно.

## ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 10 дугаар сарын байдлаар орон сууцны үнийн индекс өмнөх сараас 2.0%-иар, өнгөрсөн оны мөн үеэс 11.5%-иар тус тус буурчээ.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



Тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ орон сууцны үнэ харьцангуй тогтвортой, хуучин орон сууцны үнийн уналт үргэлжилсэн хэвээр байгаа нь орон сууцны дундаж үнэ буурахад нөлөөлж байна.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэн орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014 оны 3 дугаар сард хамгийн өндөр буюу 23.7%-тай гарсан байна. 2014 оны 12 дугаар сараас орон сууцны үнэ (өмнөх оны мөн үетэй харьцуулахад) буурч эхэлсэн бөгөөд 2015 оны 10 дугаар сарын орон сууцны үнийн жилийн бууралт нь хамгийн доод түвшиндээ буюу -11.5 хувьд хүрчээ.

Жишээ: ХУД-ийн “Рапид харш” хороололд 2014 оны 10 дугаар сард 1 м<sup>2</sup> дундаж үнэ 2,420,000 төгрөг байсан бол 2015 оны 10 дугаар сарын байдлаар 2,163,000 төгрөг болж 10.7%-иар буурсан байна.

## 1. Шинэ орон сууцны үнэ<sup>1</sup>


Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 10 дугаар сарын байдлаар 2,047,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 3.6%-иар буурсан байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.10/

Орон сууцны дундаж үнэ	2,047,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-3.6%
Сарын өсөлтийн хувь	0.0%
Хамгийн өндөр үнэтэй	Хан-Уул
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан


<sup>1</sup> Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Хан-Уул дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/




## 2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр<sup>2</sup>

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ<sup>3</sup> нь 2015 оны 10 дугаар сарын байдлаар 86,980,000 төгрөг болж өмнөх сараас 2.0 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 12.0 хувиар тус тус буурсан байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.10/


Орон сууцны дундаж үнэ	86,980,000 төгрөг
Жилийн өсөлтийн хувь	-12.0%
Сарын өсөлтийн хувь	-2.0%
Хамгийн өндөр үнэтэй	Сүхбаатар
Хамгийн бага үнэтэй	Сонгино хайрхан

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /сар.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /сар.төгрөг/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

<sup>2</sup> Иргэдийн хувьд 2 өрөө байр худалдан авах боломж нь 3-4 өрөө байр худалдан авах боломжоос харьцангуй их.

<sup>3</sup> 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)